



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/399

Улаанбаатар хот

Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж  
үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн 10.1.3, 10.2 дахь заалтыг үндэслэн, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Өсвөр үеийн кабинетийн үлгэрчилсэн дүрэм”-ийг нэгдүгээр, “Өсвөр үеийн кабинетийн их эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар”-ыг хоёрдугаар, “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багц”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өсвөр үеийн кабинетийг шаардлагатай хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой үйл ажиллагаа явуулахыг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилогоо, эмчилгээний төвийн дарга, захирал нарт даалгасугай.

3. Өсвөр үеийн багц тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэхийг сум, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн дарга, захирал дарга нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нар, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЦОГЦЭЦЭГ

081310

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 10 сарын 17-ны өдрийн  
А/344 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



## ӨСВӨР ҮЕИЙН КАБИНЕТИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

### Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дүрмийн зорилго нь Өсвөр үеийн кабинет (цаашид “Кабинет” гэх)—ийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, бусад этгээдтэй харилцах хэлбэр, кабинетийн мэргэжилтнүүдийн эрх, үүргийг тодорхойлоход оршино.

1.2 Кабинет нь энэхүү дүрэм болон Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

### Хоёрдугаар бүлэг. Нэр томъёоны тайлбар.

Энэхүү дүрэмд хэрэглэсэн зарим нэр томъёог дараах байдлаар ойлгоно.

2.1 “Өсвөр үе” гэж 10-19 насыг;

2.2 “Залуучууд” гэж 15-24 насны хүн амыг;

2.3 “Өсвөр үеийн эмч” гэж өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн эмчийг;

2.4 “Өсвөр үед ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ” гэж өсвөр үеийнхэнд зориулсан чанартай, чирэгдэлгүй, тохиромжтой, хүртээмжтэй, нууцлалыг хангасан эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг;

2.5 “Үйлчлэх хүрээний хүн ам” гэж кабинетийн байрлаж буй нутаг дэвсгэрт байнга буюу түр оршин сууж буй өсвөр үеийнхэн, залуучуудыг хэлнэ.

### Гуравдугаар бүлэг. Кабинетийн үйл ажиллагааны үндсэн зарчим

3.1 Кабинет нь өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ дор дурьдсан үндсэн зарчмуудыг баримтлана. Үүнд:

3.1.1 Өсвөр үеийнхэн, залуучуудын эрх ашиг, хүний эрхийг дээдлэх,

3.1.2 Жендерийн тэгш байдлыг хангаж ажиллах,

3.1.3 Хувийн нууцыг хадгалах,

3.1.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад ээлтэй байх,

3.1.5 Үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх

3.1.6 Өсвөр үеийнхэн, залуучуудын оролцоонд тулгуурлах

### Дөрөвдүгээр бүлэг. Кабинетийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт

4.1 Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд Өсвөр үеийн эрүүл мэндийн лавлагаа клиник ажиллаж, бусад кабинетийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

4.2 Кабинет нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн бүтцэд ажиллана.

4.3 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ нь кабинетийн үйл ажиллагаанд бодлого, удирдлага, санхүүгийн дэмжлэг үзүүлэн, өсвөр үеийн эмч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтанд хамруулна.

4.4 Кабинет нь үйлчлэх хүрээний хүн амдэрүүл мэндийн ээлтэй тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

### **Тавдугаар бүлэг. Ерөнхий шаардлага**

5.1 Кабинет нь эмч, нийгмийн ажилтан болонорон тооны бус сэтгэл зүйч/зөвлөхийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллана.

5.2 Кабинетийн нийгмийн ажилтнаар өсвөр үеийн чиглэлээр мэргэшсэн нийгмийн ажилтан, сувилагч, бага эмч ажиллаж болно.

5.3 Нэгдсэн эмнэлэг, БОЭТ тухайн жилийн төсөвтөө багтааж зөвлөгчийг ажиллуулна.

5.4 Кабинет нь өсвөр үеийнхэн, залуучуудын эрхийг дээдэлсэн, чанартай, үр дүнтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тавилга, компьютер, интернет, ном товхимол болон бусад хэрэгцээт зүйлээр бүрэн хангагдсан байна.

5.5 Кабинет нь үзлэгийн өрөө, зөвлөгөө өгөх өрөө, сургалтын өрөөтэй байна.

5.6 Кабинет нь өсвөр үеийнхэн, залуучуудад эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг удаагийн үзлэгийн багаж, эм хэрэгслээр хангагдсан байна.

5.7 Кабинет нь өөрийн үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн талаар мэдээллийн сан үүсгэн, баяжилтыг тогтмол хийнэ.

5.8 Кабинет нь өөрийн үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн хэрэгцээний байдалд тогтмол үнэлгээ, судалгаа хийж, шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй зохион байгуулна.

5.9 Кабинет нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллана.

### **Зургаадугаар бүлэг. Үйл ажиллагааны чиглэл**

6.1 Кабинет нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

6.1.1 Өсвөр үеийн эрүүл мэндийн талаар лавлах мэдээллийн багц бэлтгэн, өсвөр үеийнхэн болон тэдний эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт сургалт, сурталчилгаа зохион байгуулах,

6.1.2 Өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эмчлэн эрүүлжүүлэх, зөвлөгөө өгөх,

6.1.3 Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн асуудлаар боловсрол, нийгмийн хамгааллын болон бусад салбарынхантай хамтран ажиллан, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах,

6.1.4 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, ЕБС, МСҮТ, их, дээд сургууль, коллежийн эмч, өсвөр үеийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай нягт хамтран ажиллах,

6.1.5 Кабинетийн үйл ажиллагааны тайланг ЭХЭМҮТ-ийн тандалт судалгааны албанд улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор онлайнаар мэдээлж байх,

6.1.6 Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн чиглэлээр тулгамдаж байгаа асуудлын талаар судалгаа хийх

## **Долоодугаар бүлэг. Кабинетийн ажиллах бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарь.**

- 7.1 Эмч нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
- 7.1.1 Кабинетийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах;
  - 7.1.2 Өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх,
  - 7.1.3 Өсвөр үеийнхэн, залуучуудад сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх,
  - 7.1.4 Үе тэнгийн сургагч багш нарыг бэлтгэх, хамтран ажиллах,
  - 7.1.5 Төрийн болон төрийн бус байгууллагатай өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн асуудлаар хамтран ажиллах,
  - 7.1.6 Урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт сурталчилгаа зохион байгуулах,
  - 7.1.7 Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн асуудлаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт явуулах,
  - 7.1.8 Өсвөр үе, залуучуудад эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ эх барих, эмэгтэйчүүдийн эмч, БЗДХ, лабораторийн болон бусад төрөлжсөн мэргэшлийн эмч нартай хамтран ажиллах.
- 7.2 Нийгмийн ажилтан нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
- 7.2.1 Үйлчлүүлэгчийн карт нээх, хөтлөх;
  - 7.2.2 Үйлчлүүлэгчийг шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээнд шилжүүлэх, хяналт тавих
  - 7.2.3 Кабинетийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ЭХЭМҮТ болон холбогдох бусад газарт мэдээлэх,
  - 7.2.4 Үйлчлүүлэгч, түүний эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах,
  - 7.2.5 Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн талаар батлагдсан хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлж, мэдээлэл сургалт сурталчилгаа явуулах,
  - 7.2.6 Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэн, баяжилтийг жил бүр хийх.
- 7.3 Кабинетийн орон тооны бус зөвлөх/сэтгэл зүйч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 7.3.1 Өсвөр үеийнхэн, залуучуудад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн оношилгоо, эмчилгээ хийх,
  - 7.3.2 Шаардлагатай үйлчлүүлэгчдийг хяналтанд авах.

## **Наймдугаар бүлэг. Кабинетийн цагийн хуваарь**

- 8.1 Кабинет нь Даваа гаригаас Баасан гаригт буюу ажлын 5 өдөр, найман цагаар ажиллана.
- 8.2 Кабинетийн ажлын цагийн хуваарийг үйлчлүүлэгчдэд ил тод байрлуулах ба өсвөр үеийнхэн, залуучууд олноор цугладаг сургууль, дотуур байр зэрэг газруудад байршуулж болно.
- 8.3 Кабинет нь орон нутгийн онцлог, үйлчлүүлэгчдэд тохирсон уян хатан цагийн хуваарьтай байж болох ба цагийн хуваарийг тухайн байгууллагын даргаар баталгаажуулан мөрдөнө.
- 8.4 Клиникийн ажиллах цагийн хуваарийн жишиг загвар.

Үйл ажиллагаа	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
08:00–12:00	Үзлэг, эмчилгээ хийх	Үзлэг, эмчилгээ хийх, зөвлөгөө өгөх	ЕБС бусад сургуулиудад сургалт явуулах	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	Үйлчлэх хүрээний хүн амын дунд сургалт зохион байгуулах
12:00-13:00	Үдийн завсарлага				
13:00–17:00	Зөвлөгөө өгөх	Үйлчлэх хүрээний хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг хийх	ЕБС бусад сургуулиудад сургалт явуулах	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	Үзлэг эмчилгээ, зөвлөгөө өгөх

2017 оны 10 сарын 17-ны өдрийн  
 АЗГД дугаар тушаалын 2 дугаар хавсралт



**ӨСВӨР ҮЕИЙН КАБИНЕТИЙН ИХ ЭМЧИЙН  
 АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

**А. ТАНИЛЦУУЛГА**

1. Байгууллагын нэр ..... аймаг/дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ	2. Нэгжийн нэр Өсвөр үеийн кабинет	
3. Ажлын байрны нэр Өсвөр үеийн их эмч	3.1. Албан тушаалын ангилал Засгийн газрын тогтоолд зааснаар	3.1. Албан тушаалын зэрэглэл Засгийн газрын тогтоолд зааснаар
4. Ажлын байрыг харьяалан удирдах тушаалын нэр шууд албан	4.1. Албан тушаалын ангилал Засгийн газрын тогтоолд зааснаар	4.1. Албан тушаалын зэрэглэл Засгийн газрын тогтоолд зааснаар
5. Ажлын байрны харьяалан удирдах тушаал шууд албан	5.1. Албан тушаалын нэр	5.2. Албан тушаал эрхлэгчдийн тоо /Батлагдсан орон тооны дагуу/

**Б. АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРЭГ**

1. Ажлын байрны зорилго	Өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, ЭМБ олгох, эрүүл аж төрөх дадал хэвшлийг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах
1. Ажлын байрны үндсэн зорилт	<ul style="list-style-type: none"> <li>- Өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн ээлтэй цогц тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх</li> <li>- Кабинет болон ЕБС-ийн уялдаа холбоог ханган, сургуулийн эмч нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах</li> <li>- Өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх дадал хэвшлийг эзэмшүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах</li> <li>- Мэргэжлийн чиглэлээр сургалтанд хамрагдах, мэдлэг, боловсролоо дээшлүүлэх</li> </ul>

3. Ажлын байрны гол үйл ажиллагаа:	Хугацаа, хуваарь
<p><b>3.1. Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Өсвөр үеийнхэн, залуучуудын хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн ээлтэй цогц тусламж үйлчилгээг үзүүлэх, оношлогоо эмчилгээний түгээмэл үйлдлийн стандартыг мөрдлөг болгон ажиллах</li> <li>- Өсвөр үеийнхэн, залуучуудын бие бялдрын ерөнхий үзүүлэлтэд үнэлэлт өгч, үзлэг шинжилгээ хийж онош тогтоох ба төрөлжсөн мэргэшлийн эмч нартай хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд дараагийн шатны үйлчилгээнд өвчтөн шилжүүлэх журмын дагуу илгээх</li> <li>- Шаардлагатай эмчилгээ үйлчилгээг зохих журмын дагуу үзүүлэх ба эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар зөвлөгөө өгч ажиллах</li> <li>- Өсвөр үеийнхэн, залуучуудын өвчлөлийн үзүүлэлтэд судалгаа, дүгнэлт хийж, тусламж үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах талаар санал дэвшүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч байх</li> <li>- Хамрах хүрээний хүн амд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, эрүүлжилтэнд хяналт тавьж ажиллах</li> <li>- Өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой анхан шатны бүртгэл маягт, картыг үнэн зөв хөтөлж, шаардлагатай мэдээ тайланг цаг хугацаанд нь гаргаж байх</li> </ul>	<p>-Тогтмол</p> <p>- Тогтмол</p> <p>-Тогтмол</p> <p>-Тогтмол</p> <p>-Жилд 2 удаа</p> <p>-Тогтмол</p>
<p><b>3.2. Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Өсвөр үеийнхэн, залуучуудын дунд зонхилох өвчлөл болон зан үйлийн байдалд үнэлэлт өгч, судалгаа шинжилгээнд үндэслэсэн бүтээлч, шинэлэг үйл ажиллагааг эрчимжүүлэх аян, уралдаан тэмцээнийг оюутан, сурагчдын дунд зохион байгуулах, шагнаж урамшуулах</li> <li>- Сургуулийн эмч нарыг нэгдсэн эмнэлгийн эмч нартай холбон ажиллаж оюутан сурагчдыг шаардлагатай тусламж үйлчилгээнд илгээх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах</li> <li>- ЕБС, их, дээд сургууль, коллежийн орчин нөхцлийг сайжруулах, эмч, багш нарын эрүүл мэндийг хамгаалах талаар нөлөөллийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх</li> </ul>	<p>- Тухай бүр</p> <p>- Тогтмол</p> <p>- Тогтмол</p> <p>-Жилд 1 удаа</p> <p>-Тогтмол</p>
<p><b>3.3 Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Өсвөр үеийнхэн, залуучуудын эрүүл амьдрах, хөгжих орчин, нөхцөл бүрдүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт арга зүйн ажлыг зохион байгуулахад Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах</li> <li>- Эмзэг, зорилтод бүлгийн өсвөр үе, залууст амьдрах ухаан, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион явуулж, өсвөр үеийнхэн, залуучуудын хэрэгцээнд нийцсэн гарын авлага материал боловсруулах</li> <li>- “Үе тэнгийн сургагч” бэлтгэх сургалтыг ЕБС-н идэвхтэн сурагч нарт хийж, хүүхэд хүүхэддээ нөлөөлөх ажлыг дэмжин ажиллах</li> <li>- Сар бүрийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдээр хөтөлбөр, стратеги хариуцсан эмч нартай хамтран өсвөр үе, залуусын дунд эрүүл мэндийн сургалт сурталчилгаа зохион явуулах</li> </ul>	<p>-Тогтмол</p> <p>-Тогтмол</p> <p>- Тогтмол</p> <p>- Тогтмол</p> <p>-Улирал бүр</p> <p>-Сар бүр</p>

<b>3.4. Ажлын байрны IY үндсэн зорилтын хүрээнд:</b>	
- Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, стандарт болон холбогдох зааврыг мөрдөж ажиллах	-Тогтмол
- Өөрийн кабинетийн нийгмийн ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаархангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх	-Тогтмол
- Байгууллагын дотоод үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцох	-Тогтмол
- Олон нийтийн ажилд оролцох, санал санаачлага гаргах, хэрэгжүүлэх	-Тогтмол
- Өөрийн мэдлэг, ур чадвар, мэргэшлийг байнга дээшлүүлэх, сургалтанд хамрагдах	-Тогтмол
- Төгсөлтийн дараах сургалтанд хамрагдах	-Тогтмол
- Хэлний мэдлэгээ дээшлүүлэхэд анхаарах	-Тогтмол

### В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Ажлын байранд тавигдах шаардлага	Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай
			Боловсрол
1.1. Ерөнхий шаардлагууд	Мэргэжил	Хүүхэд, дотор, өрхийн их эмч	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын чиглэлээр мэргэшсэн
	Мэргэшил	Төгсөлтийн дараах өсвөр үеийн анагаах ухааны чиглэлээр мэргэшсэн байх	
1.2. Тусгай шаардлага:	Туршлага	Хүүхэд, дотор, өрхийн эмчээр 3-аас доошгүй жил ажилласан	Мэргэжлээрээ ажилласан дадлага туршлагатай байх
	Урчадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжлээрээ ажиллах чадвартай</li> <li>• Багаар ажиллах чадвартай</li> <li>• Харьцааны соёлтой</li> <li>• Судалгааны арга зүй эзэмшсэн</li> <li>• Бүтээлч санаачлагатай</li> <li>• Ачаалал даах</li> <li>• Хариуцлага хүлээх</li> <li>• Нууц хадгалах</li> <li>•</li> </ul>	
		<ul style="list-style-type: none"> <li>▪ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах</li> <li>▪ Авилгын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авилгаас ангид байх</li> <li>▪ Холбогдох хууль тогтоомж, дүрэм зааврыг сайтар судалж, хэрэгжүүлдэг</li> <li>▪ Сонсох, хүлээцтэй байх</li> <li>▪ Гамшгийн үед дайчлагдах, бэлэн байдлыг ханганажиллах</li> </ul>	

**Г. ХҮЧИН ЗҮЙЛС**

1. Ажлын байрны харилцах субъект:		
<b>1.1. Байгууллагын дотор талд байгаа:</b> - Байгууллагын дарга, удирдах ажилтан - Удирдах зөвлөл - Ёс зүйн хэсгийн хороо - Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга, ажилтан, албан хаагч - Эрүүл мэндийн төвийн ажилтан, албан хаагч	<b>1.2. Байгууллагын гадна талд байгаа:</b> - Үйлчлүүлэгч, түүний ар гэр, асран хамгаалагч - ЕБС, их, дээд сургууль, коллежийн удирдлага, эмч нар - Сум, өрх, тосгоны ЭМТ, сум дундын эмнэлэг - Мэргэжлийн байгууллага, нийгэмлэг, холбоо - Төрийн болон төрийн бус байгууллага, ОУБ болон бусад байгууллага	
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг нэгдсэн эмнэлгийн дарга, бусад ажилтан, холбогдох хэлтэс, албадын даргын өмнө хариуцана.	
3. Ажлын байрны нөөц хэрэгсэл	3.1. Санхүүгийн	- Үндсэн цалинг засгийн газрын тогтоолын дагуу тооцож олгох - Хууль тогтоомжийн дагуу нэмэгдэл, бусад нэмэгдэл, урамшуулал олгох
	3.2. Материалын	- Шаардлагатай хүлээлгэж өгсөн эд хөрөнгө - Ажлын байрны стандартыг хангасан өрөө - Компьютер, дагалдах хэрэгслийн хамт - Ажлын хувцас, Хамгаалах хэрэгсэл - бичгийн хэрэгсэл - Дотоод сүлжээ, дотуур холбоо, утас
	3.3. Хүний	Байгууллагын ажилтнуудтай хамтран ажиллах
	3.4. Бусад	Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд жил бүр үнэ төлбөргүй хамрагдах
4. Ажлын байрны нөхцөл	4.1. Ердийн нөхцөл 4.2. Онцгой нөхцөл	Ердийн

**Д. БАТАЛГААЖУУЛАЛТ**

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан
..... (Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан албан тушаалтны эцэг эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр ) ..... (гарын үсэг) .... оны ... дугаар сарын ...-ны өдөр	..... (Ажлын байрны тодорхойлолтыг баталсан албан тушаалтны эцэг эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр ) ..... (гарын үсэг) .... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 10 сарын 17-ны өдрийн  
А/399 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



## ӨСВӨР ҮЕИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ

**НЭГ. Сум, өрх, тосгоны ЭМТ, сум дундын эмнэлгийн түвшинд**

**Зорилт:**

1. Сум, өрх, тосгоны ЭМТ, сум дундын эмнэлгийн эмч, сувилагч нар өсвөр үеийнхний эрэлт хэрэгцээнд нийцсэн, үр дүнтэй тусламж үйлчилгээг хүртээмжтэй үзүүлнэ.
2. Аймаг, дүүргийн хэмжээнд өсвөр үеийнхэнд зориулсан эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаар тодорхой мэдээлэлтэй байж, шаардлагатай тохиолдолд үндсэн мэргэшлийн үйлчилгээнд шилжүүлэхийн зэрэгцээ үйлчлүүлэгчдийг энэ талын мэдээллээр хангана.

**Үйлчилгээ үзүүлэгчид:**

- Сум, өрх, тосгоны ЭМТ, сум дундын эмнэлгийн эмч, сувилагч, бага эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нар

**Тусламж үйлчилгээний багц:**

1. Өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах тав тухтай, нууцлалыг хангасан ээлтэй орчин бүрдүүлэх
2. Эрүүл мэндийн боловсрол олгох
3. Дархлаажуулалтад хамруулах
4. Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар зөвөлгөө өгөх
5. Үе тэнгийн сургагч бэлдэх
6. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх
7. Дараагийн шатлал руу шилжүүлэх
8. Эрсдэлт зан үйлийг илрүүлэх, түүнийг өөрчлөхөд чиглэсэн мэдээлэл, сургалт, суртачилгаа явуулах, хамтран ажиллах
9. Өсвөр үе, үйлчлүүлэгчдийн бүртгэл, мэдээллийг хөтлөх
10. Харьяа нутаг дэвсгэрийн ЕБС, их, дээд сургууль, коллежийн удирдлага, эмч нартай нягт хамтран ажиллаж, оюутан, сурагчдын эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх
11. Орон нутгийн засаг захиргаа, удирдлагуудад өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр ухуулга нөлөөллийн үйл ажиллагаа явуулж, өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сургуулийн эрүүл мэндийн хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэх

**Сум, өрх, тосгоны ЭМТ, сум дундын эмнэлэгт өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж**

№	Эм, багаж хэрэгслийн нэрс	Нэгж	Тоо хэмжээ
2	Гар нурууны хүч хэмжигч	ш	1-2
3	ӨЭМТ- ийн яаралтай тусламжийн эм тариа ( Иж бүрдлээр)	багц	1-2
	Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл		
	Түргэвчилсэн оношлуур		
	Охидын үзлэгийн ор		
	Үзлэгийн ор(кушетка)		
	Үзлэгийн гэрэл		
4	Өндөр, жин хэмжигч	Тус бүр	1
5	Пульсоксиметр	Тус бүр	1-2
6	Оториноскоп	ш	1-2
7	Хараа шалгах хүснэгт	ш	1
11	Физик эмчигээний тоног төхөөрөмж, иж бүрдлээр	Иж бүрдэл	хэрэгцээгээр
12	Сургалт, сурталчилгааны ном, товхимол, материал	Тус бүр	хэрэгцээгээр
13	Биеийн болон эрхтэн тогтолцооны бүтэц зохион байгуулалтыг харуулсан үзүүлэн, муляж	ш	хэрэгцээгээр

**ХОЁР. Аймаг/ Дүүргийн өсвөр үеийн кабинет**

**Зорилт:**

1. Өсвөр үеийн кабинетийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаар олон нийтэд мэдээлдэг байна.
2. Өсвөр үеийн кабинет нь өсвөр үеийнхэн, залуучуудын анхаарлыг татахуйц үйл ажиллагаа явуулж, тэдний хүсэл сонирхолд нийцсэн байдлаар тохижуулсан байхын зэрэгцээ өсвөр үеийнхэн тусламж үйлчилгээ авахад байрлал, ажиллах цаг, үйлчилгээний хэлбэрийн хувьд тохиромжтой байна.
3. Эрүүл мэндийн ажилтнууд өсвөр үеийн кабинетээр үйлчлүүлсэн өсвөр үеийнхэн, залуучуудын хувийн нууцыг хадгална.
4. Өсвөр үеийн кабинетийн эмч, ажилтнууд өсвөр үеийнхний эрүүл мэнд, хөгжлийн асуудлаар сургалтанд хамрагдсан байна.

**Үйлчилгээ үзүүлэгчид:**

- Аймаг, дүүргийн өсвөр үеийн кабинетийн эмч, сувилагч, бага эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар

**Тусламж үйлчилгээний багц:**

1. Өсвөр насны хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн өвөрмөц үзлэг шинжилгээг хийх
2. Охид, хөвгүүдийн амбулаторийн үзлэг, шинжилгээ, оношлогоо хийх
3. Өсвөр үеийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
4. Сум, өрх, тосгоны ЭМТ, сум дундын эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан нарыг өсвөр үеийн эрүүл мэндийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулах

5. Төрөлжсөн мэргэшлийн эмч нартай хамтран ажиллах
6. Өсвөр үеийнхний өсөлт хөгжил, бие бялдрын хөгжилд үнэлэлт дүгнэлт өгөх
7. Шаардлагатай тохиолдолд дээд шатлалын үйлчилгээнд шилжүүлэх
8. Өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох албан бус сургалтыг зохион байгуулах
9. "Өсвөр үеийн зөвлөл"-ийг байгуулж, хамтран ажиллах
10. Үйлчлүүлэгчдийн бүртгэл мэдээлэл цуглуулах, мэдээллийн сан байгуулж дүгнэлт хийх
11. Өсвөр үеийнхэн, залуучуудын эрүүл мэндийн болон тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээ шаардлагыг судлан тодорхойлох
12. Үе тэнгийн сургагч бэлдэх
13. Харьяа нутаг дэвсгэрийн ЕБС, их, дээд сургууль, коллежийн удирдлага, эмч нартай нягт хамтран ажиллаж, оюутан, сурагчдын эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх
14. Орон нутгийн засаг захиргаа, удирдлагуудад өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр ухуулга нөлөөллийн үйл ажиллагаа явуулж, өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сургуулийн эрүүл мэндийн хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэх

**Аймаг/ Дүүргийн өсвөр үеийн кабинетэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж:**

№	Эм, багаж хэрэгслийн нэрс	Нэгж	Тоо хэмжээ
	Эмчийн ширээ сандал, хүүхэд үзэх ор, кушетка	Тус бүр	1-2
	Охидын ор	ш	1
	Пульсоксиметр	ш	1
	Оториноскопи	ш	1
	Яаралтай тусламжийн бикс	ш	Иж бүрдэл
	Чагнуур, даралтын аппарат	Тус бүр	1
	Өндөр, жин хэмжигч	Тус бүр	1
	Туузан метр, гар нурууны хүч хэмжигч	Тус бүр	1-2
	Чангалуур	ш	2-3
	Халуун шил	ш	2-3
	Лотошка	ш	1-3
	Охидын толь	ш	хэрэгцээгээр
	Түргэвчилсэн оношлур	ш	хэрэгцээгээр
	Микроскоп	ш	1
	Наацын шинжилгээний бүрдэл, граммын будаг	Тус бүр	1-2
	Өсвөр үеийн эмчийн яаралтай тусламжийн эм тариа (Иж бүрдлээр)	багц	Иж бүрдэл
	Нашатырь спирт, бинт хөвөн	ш	2-3
	Иод, метилийн хөх	ш	2-3
	Кварц	ш	1
	Хараа шалгах хүснэгт	ш	1
	ЖСА эм, хэрэгсэл	Тус бүр	хэрэгцээгээр
	Сургалт, сурталчилгааны ном,	ш	хэрэгцээгээр

	товхимол, материал		
	Эрүүл мэндийн карт баримт хадгалах шүүгээ, номын шкаф	Тус бүр	1
	Биеийн болон эрхтэн тогтолцооны бүтэц зохион байгуулалтыг харуулсан үзүүлэн, муляж	ш	хэрэгцээгээр

### Сургалт сурталчилгааны тоног төхөөрөмж

1. Ном, сурталчилгааны материал хийх шкаф
2. Компьютер
3. Принтер
4. Проектор
5. Сургалтын ширээ, сандал
6. Тусгаарлах хаалт
7. Бичгийн ширээ, сандал
8. Зөвлөгөө өгөх ширээ, сандал
9. Сурталчилгааны тавиур

### ГУРАВ: АМЬДРАЛЫН БОЛОН ӨВЧНИЙ ТҮҮХ ЦУГЛУУЛАХ, АСУУЛГА АВАХ

Ерөнхий чиглэл: Өсвөр үеийнхэн, залуучуудаас амьдралын болон өвчний түүх цуглуулах нь тэдний өсөлт бойжилт, эрсдэлтэй байдлыг үнэлэх, зан үйлийн төлөвшилтийг тогтоох, өвчнийг оношлох, эмчлэхэд чухал ач холбогдолтой. Үйлчлүүлэгч эхний удаа ирэх үед дэлгэрэнгүй түүхийг нь хавсралтад байгаа маягтын асуултуудын дагуу авч баримтжуулж, архивт хадгална.

- 1.1. Амьдралын болон өвчний түүх цуглуулах зорилго:
  - Өсвөр үеийнхэн, залуучуудын биеийн ерөнхий болон бэлгийн бойжилт хэвийн явагдаж байгаа эсэхийг тогтоох,
  - Урьд нь өвчилж байсан өвчний талаар мэдээлэлтэй болох,
  - Өвчнийг зөв оношлох,
  - Ямар тусламж шаардлагатай байгааг мэдэх,
  - Цаашид үндсэн буюу төрөлжсөн мэргэшлийн эмчид хандах хэрэгцээ, шаардлагыг тогтоох,
  - Эрүүл мэндийн эрсдэлтэй зан үйл (Бэлгийн олон хавьтагчтай байх, биеэ үнэлэх, согтууруулах ундаа ба мансууруулах бодис хэрэглэх болон бусад) байгаа эсэхийг тогтоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.
  - БЗДХ –ын үед хавьтал судлал хийх
- 1.2. Асуулга авахдаа баримтлах зарчмууд
  - Үйлчлүүлэгчтэй найрсаг харьцаа тогтоож, түүнд тохиолдсон бэрхшээл, бусад асуудлаа ярих тааламжтай нөхцлийг бүрдүүлнэ .
  - Ярилцлагын эхэнд өөрийгөө заавал танилцуулна.
  - Нууцыг хадгална гэдгийг онцлон хэлнэ.
  - Үйлчлүүлэгч эцэг, эх буюу асран хамгаалагч/харгалзан дэмжигчийн хамт ирвэл тэднийг байлгах эсэхийг зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.
  - Өсвөр үеийнхэн, залуучуудтай харьцахдаа үе тэнгийнхний, дотны найзын байр сууринаас хандана.
  - Тэднийг анхааралтай сонсоно.
  - Ярихдаа үйлчлүүлэгчийн нас, хөгжилд тохирох энгийн үг хэллэг хэрэглэнэ.

- Шаардлагатай үед чиглүүлэх, лавлах, нээлттэй асуултыг тавих зэрэг арга, техникийг хэрэглэнэ.
- Үйлчлүүлэгчид шүүмжлэлтэй хандаж байгаа байдал гаргахгүй.
- Эмзэг асуудлын талаар ярилцахдаа үйлчлүүлэгчээс зөвшөөрөл авна.

## ДӨРӨВ: ҮЗЛЭГ ХИЙХ

Ерөнхий чиглэл: Анх үзүүлж байгаа өсвөр үеийнхэн, залуучуудад эмч бүх биеийнүзлэг хийнэ. Анхны үзлэг болон цаашид хийгдэх үзлэг бүрийн тэмдэглэл хөтлөн баримтжуулж, архивт хадгална.

### 2.1. Ерөнхий үзлэг

Биеийн жин, өндрийг заавал тодорхойлно.

#### Арьсны үзлэг:

Арьсны өнгө, уян чанар, чийглэг байдлыг үзэхийн зэрэгцээ загатнаа, тууралт байгаа эсэхийг үзнэ.

#### Нүд:

Нүдний хараа шалгана. Офтальмоскопоор нүдний угийг шинжилнэ.

#### Чих, хамар, хоолой:

Чих, хамрыг отоскопоор шинжилнэ. Залгиур, гүйлсэн булчирхайг үзэхдээ отоскопийн гэрлийг ашиглана.

#### Шүд ба амны хөндий:

Өвчтэй шүд, буйлны үрэвсэл байгаа эсэх, шүдний буруу ургалт ба эрүүний гажгийг илрүүлэх үзлэг хийнэ. Хэлний өнгө, өнгөртэй, чийглэг эсэхийг үзнэ. Амны хөндийн үзлэг хийхдээ отоскопын гэрлийг ашиглана.

#### Хүзүү:

Хүзүү орчимд үзлэг хийхдээ тунгалгийн булчирхай, бамбай булчирхайг тэмтрэн үзнэ.

#### Цээж:

Цээжний хэлбэр зөв эсэхийг үнэлнэ. Эгэмний доорхи тунгалгийн булчирхайг тэмтэрнэ.

#### Нуруу:

Шилжилтийн насанд хүүхэд хурдан өсдөг учир нурууны муруйлт (сколиоз) үүсэх нь элбэг байдаг. Тиймээс нурууны муруйлт байгаа эсэхийг тодорхойлно. Нурууны муруйлт байгаа эсэхийг дараах аргыг хэрэглэж, доорх шинжүүд дээр үндэслэн илрүүлнэ:

1. Үйлчлүүлэгчийгтэгшхэн зогсоогоод урдаас нь харахад хоёр мөр нь дээр доор байна,
2. Араас нь харахад далны өнцөг нь нэг түвшинд биш байна,
3. Үйлчлүүлэгчийнхоёр гарыг нь доош нь унжуулаад тонгойлгоход нурууны муруйлт сайн харагдана.

Нурууны муруйлтыг хэмээр хэмжинэ. Бэлгийн бойжилтын 1-р ба 2-р зэрэглэлд байх үедээ 10-15 хэмээс дээш муруйлт байвал түүнийг даруй засах арга хэмжээ авна. Бэлгийн бойжилтын хожуу үед муруйлт засардаггүй.

#### Мэдрэлийн үзлэг:

Тархины 12 хос мэдрэлийн үйл ажиллагаа, бусад мэдрэлийн рефлексүүдийг үзнэ.

#### Зүрх судасны тогтолцоо:

Зүрхийг үндсэн таван цэгт чагнана, шаардлагатай үед нэмэлт цэгүүдэд чагнана. Захын судасны лугшилтын тоо, хүчдэл дүүрэлтийг үзэж, артерийн даралтыг хэмжинэ.

#### Амьсгалын эрхтний тогтолцоо:

Уушгийг хоёр талд чагнана. Шаардлагатай үед харьцуулсан тогшилтыг хийнэ, мөн уушигны хил хязгаар, займчих хязгаарыг тодорхойлно.

#### Хэвлий:

Баруун доод хэсгээс эхлэн нийт хэвлийг зөөлөн тэмтэрч үзнэ. Эмзэглэлтэй эсэх, хэвлийн булчингийн чангарал, ямар нэгэн үүсгэвэр байгаа эсэхийг үзнэ. Элэг, дэлүү тэмтрэгдэж байгаа эсэх, эмзэглэлтэй эсэхийг үзнэ. Шаардлагатай үед элэгний хил хязгаарыг тогшиж тогтооно.

#### Шээс, бэлгийн зам:

Пастернацкийн шинж илэрч байгаа эсэх, хөл хавантай эсэхийг үзнэ. Охид, хөвгүүдэд тусгайлсан үзлэг хийх үед бэлгийн бойжилт, бэлэг эрхтний хөгжлийг үнэлнэ.

### **2.2. Тусгайлсан үзлэг**

Бүх биеийн үзлэг хийхдээ бэлгийн бойжилтын үе шатыг Таннерийн үе шатлалын дагуу заавал тодорхойлно. Тусгайлсан үзлэгийн өмнө бэлгийн бойжилт хэрхэн явагдаж байгааг үнэлэх зорилгоор үзлэг хийх гэж байгаагаа хэлж, зөвшөөрөл авна. Үзлэг, ажилбарыг тодорхой тайлбарлан тусгайлсан үзлэг хийнэ. Үйлчлүүлэгч зөвшөөрөөгүй тохиолдолд тусгайлсан үзлэг хийхгүй.

#### Хөвгүүдэд хийх тусгайлсан үзлэг

##### 1. Хөхний үзлэг

Хөвгүүдийн 30%-д бэлгийн бойжилтын үед хөх томорч, хөндүүрлэх байдал (гинекомасти) тохиолддог. Хэрэв хөх томорсон байвал санаа зоволтгүй, энэ нь хэвийн үзэгдэл, хэсэг хугацааны дараа зүгээр болно гэдгийг хэлнэ. Цаашид давтан үзлэгийн үед ажиглалт хийнэ.

##### 2. Төмсөгний үзлэг

Хоёр талын төмсөг хуухнагтаа буусан эсэхийг үзнэ. Аль нэг нь бугаагүй байвал (крипторхизм) мэс заслын эмчилгээг зөвлөж, урологийн мэс заслын эмчид шилжүүлнэ. Төмсөгний эзэлхүүнийг орхиометрээр тодорхойлно. Төмсөгний дайврыг барьж өвчин эмзэглэл байгаа эсэхийг үзнэ.

##### 3. Шодойн үзлэг

Шодойны арьсыг шамалж үзэх хэрэгтэй. Тэнд ялгадас хуримтлагдсанаас бохиртох нь элбэг байдаг. Шодойн арьсыг шамалж цэвэрлэж байх хэрэгтэйг зөвлөнө (тээрхийн үрэвсэл-баланитаас сэргийлнэ). Фимоз байгаа эсэхийг тодорхойлно. Үзлэг хийх явцад шодой хөвчрөх тохиолдол гардаг. Ийм тохиолдолд тайвшруулж, энэ нь хэвийн үзэгдэл гэдгийг хэлнэ. Шодойн арьсан дээр тууралт байгаа эсэхийг тодорхойлж, хэрвээ тууралттай бол түүний хэлбэр, хэмжээ, өнгө, тогтоц, тоо, ширхэг зэргийг тодорхойлно.

Шодой, төмсөг, хуухнаг, умдагны үсжилтийн байдлаар бэлгийн бойжилтын зэргийг тодорхойлно. Улмаар үйлчлүүлэгчийн өсөлт, хөгжил хэвийн явагдаж байгаа эсэхийг үнэлнэ.

#### Охидод хийх тусгайлсан үзлэг

##### Хөхний үзлэг:

- Сандал дээр суулгаж хоёр хөхийг ажиглана (Зарим охидын 2 хөх хэмжээгээрээ бага зэрэг өөр байж болно),
- Хоёр хөх хэмжээгээрээ ижил байгаа эсэхийг ажиглана,
- Хөхний толгойн нөсөөт хэсгийг харна.
- Ямар нэгэн үүсгэвэр харагдаж байгаа эсэхийг ажиглана,
- Хөхөнд хонхорхой үүссэн эсэхийг харна,
- Арьсны өөрчлөлт байгаа эсэх (улайсан, цоохортсон),
- Хөхний толгой цаашаа татагдаж эргэсэн эсэх зэргийг үзнэ.

Хөх тэмтэрч үзэх хэд хэдэн арга хэрэглэнэ:

1. Хөхний толгойноос тал тал тийш нь тэмтрэх
2. Хөхний толгойг тойруулж тэмтрэх
3. Хөндлөн тэмтрэх

Хөхний эд нь дээшээ эгэм, дотогшоо цээжний гол шугам хүртэл үргэлжилдэг. Дунд гурван хурууны өндгөөр, тойрог хэлбэрээр, чанга дарахгүй зөөлөн тэмтэрнэ. Шаардлагатай бол шахаж үзэж болно.

#### Охидын үзлэг

Охидын үзлэгийн орон дээр гаргаад эмч хоёр гараа мөрийн хэмжээнд нь байрлуулж, хоёр хөлөө заасан хэмжээнд хүртэл дэлгэхийг охиноос хүснэ. Хөлийг нь хоёр тийш нь дэлгэж тавиур дээр тахимаар нь тавиулж дараах үзлэгийг хийнэ. Үүнд:

- Цавины булчирхай томорсонэсэх,
- Хэлүү томорсон эсэх (андрогений дааврын хэт ялгарлаасхэлүү томорно),
- Гадна бэлэг эрхтэний хөгжил зөв эсэх, үрэвслийн шинж байгаа эсэх,
- Охин хальсны байдал (хэлбэр, бүтэн эсвэл гэмтсэн),
- Үтрээний ялгадас харна (хэмжээ, өнгө, зуурамтгай чанар, үнэр),
- Бэлэг эрхтэн дээрямар нэг тууралт байгаа эсэх, хэрвээ байгаа бол түүний хэлбэр, хэмжээ, өнгө, тогтоц зэргийг тодорхойлно.

#### Үтрээнд толь тавих

Зөвхөн шаардлагатай үед л толь тавьж үзлэг хийнэ (бэлгийн харьцаанд орсон, төрсөн охидуудад). Урьдчилж толио бүлээн усанд байлгаж эсвэл гартаа бүлээцүүлбэл цочрох нь бага байдаг. Эхлээд долоовор хуруугаа үтрээнд оруулаад дээгүүр нь толио 45 хэмийн налуугаар оруулаад хуруугаа авна. Толиор умайн хүзүүний хэлбэр, үрэвсэлтэй эсэх, үтрээний хана, үтрээний ялгадсын байдлыг харна.

#### Үтрээний үзлэг

Үтрээний үзлэг, хоёр гарын үзлэгийг зөвхөн шаардлагатай үед хийнэ (бэлгийн харьцаанд орсон, төрсөн охидуудад). Дараах зүйлсийг үзнэ:

- Умайн хүзүү (урт, хаалттай эсэх),
- Умайн байрлал, хэмжээ, хөдөлгөөн, өвчтэй эсэх,
- Хоёр талын дайвар тэмтрэгдэж байгаа эсэх, өвчтэй эсэх.

### **ТАВ: ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТ (ГБТ)**

**Ерөнхий чиглэл:** Өсвөр насныхан, залуучуудад ГБТ-ийн үйлчилгээ хүртэх бодит шаардлага тулгарч байна. Үүнд өсвөр насныхан, залуучуудад тохиромжтой жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг (ЖСАХ) олгох, хэрхэн хэрэглэх талаар зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээг эмч, зөвлөгч үзүүлнэ.

#### **3.1. Өсвөр үеийнхэн, залуучуудад ГБТ -ийн үйлчилгээ үзүүлэхдээ баримтлах зарчмууд**

- Үйлчлүүлэгчээс амьдралын болон өвчний түүх цуглуулах, асуулга авах үедээ бэлгийн амьдралын түүхийг асууж, бэлгийн харьцаанд орсон, эсвэл орохыг төлөвлөж байгаа эсэхийг тодруулна,
- Бэлгийн харьцаанд орсон, эсвэл орохыг төлөвлөж байгаа охид, хөвгүүдэд ЖСАХ-ийн талаар мэдээлэл өгч, үзүүлэн, модель зэргийг ашиглаж үйлчлэх механизм, давуу болон султал, хэрэглэх заавар зэргийг танилцуулна,

- Үйлчлүүлэгчид ЖСАХ-ийн талаар МСС-ны материалыг олгох эсвэл хүлээлгийн ерөөнөөс авч болохыг зөвлөнө,
- Жирэмсэлсэн охидуудад жирэмсний хугацааг тогтоож, зөвлөгөө өгнө,
- Хүүхдээ тээхээр шийдвэрлэсэн үйлчлүүлэгчийг харъяа газрын өрх эсвэл сумын болон эх барих-эмэгтэйчүүдийн эмчийн хяналтанд шилжүүлнэ,
- Үр хөндүүлэхээр шийдвэрлэсэн охидод шаардлагатай зөвлөгөөг өгч, үр хөндөлтийн үйлчилгээ үзүүлдэг итгэмжлэгдсэн газар руу шилжүүлнэ. Арван найм хүртэлх насны охидод ямар нэгэн мэс ажилбар, үр хөндөлтийгхуулийн дагуу эцэг, эх, асран хамгаалагч/харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хийдэггүй тул тэдэндээ мэдэгдэхийг зөвлөнө.

### **Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслүүд (ЖСАХ)**

Хүсээгүй жирэмслэхээс сэргийлэх олон төрлийн арга хэрэгсэлбайдаг. Өсвөр үеийнхэнд бэлгийн хавьтлыг тэвчих, эрэгтэй бэлгэвч, дааврын эм, тарилга (Депо-Провера), яаралтай үед жирэмслэхээс сэргийлэх дааврын эм зэргийг санал болгоно. Хүсээгүй жирэмслэлтээс хамгаалахын зэрэгцээ бэлгийн замаар дамжих халдвараас (БЗДХ) сэргийлдэг ганц хэрэгсэл нь бэлгэвч тул бэлгэвчийг бусад жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг хэрэглэж байгаа ч хавсран хэрэглэхийг зөвлөнө.

#### **3.3. Жирэмслэлт**

Төвийн эмч охидын жирэмснийг оношилно.

- 1.Жирэмсний эрт болон хожуу үеийн шинж тэмдгийг харгалзана.
2. Сорил тавина. Жирэмснийг хамгийн эрт оношлох оношлуур бол шээсэнд хориаль гонадотроп даавар тодорхойлох (жирэмсний сорил).

Шээсэнд хориаль гонадотроп даавар тодорхойлох сорилыг тавих заавар:

- Тусгай саванд шээлгэж, шээсийг бэлтгэнэ. Сорилын баглааны бүрэн бүтэн байдал, хугацааг шалгана. Дараа нь уутыг нээнэ.
- Нарийн туузан сорилыгзаасан тэмдэг хүртэл шээсэнд дүрж, шээсний нэвчилтийг ажиглана.
- Таван хормын дараа туузан дээр нэг хөндлөн зураас гарвал жирэмсэн бус,хоёр хөндлөн зураас гарвал жирэмсэн гэжүзнэ.

Жирэмсний сорилоор умай ба умайн гадуурх жирэмслэлтийг ялгаж оношлох боломжгүйг анхаарна уу.

3.Үтрээний үзлэг болон толь тавьжхарна. Умайн хүзүү хөхрөнгө харагдана. Үтрээний үзлэгээр жирэмсний хугацааг тодорхойлно. Хэт авиан оношлогоогоор жирэмсний хугацааг тодорхойлуулна. Жирэмснийг оношлосны дараа өсвөр үеийнхэнд шийдвэр гаргахад тусалж зөвлөгөө өгнө. Жирэмсний аль болох эрт хугацаанд асуудлыг шийдэх нь тэдэндтустай.

- Өсвөр үеийн кабинет жирэмснийг хянах үйлчилгээ үзүүлэхгүй.
- Жирэмснээ тогтоолгосон үйлчлүүлэгч хүүхдээ тээхээр шийдвэрлэвэл, эсвэл жирэмсний хяналтанд орох хүсэлтэй хандвал өрх, сумын эмч болон эх барих-эмэгтэйчүүдийн эмчийн хяналтанд албан ёсоор шилжүүлнэ.

#### **Үр хөндөлтийн асуудал:**

- Өсвөр үеийн кабинет үр хөндөх үйлчилгээ үзүүлэхгүй.
- Арван хоёр долоо хоног хүртлэх хугацаатай жирэмсэн эмэгтэй үр хөндүүлэх хүсэлтэй бол харъяа эмэгтэйчүүдийн кабинет, төрөх газар, аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг руу шилжүүлнэ.
- 16 нас хүрээгүй өсвөр насны охины жирэмсний хугацаа арван хоёр долоо хоногоос хэтэрсэн байвал 16- 24 долоо хоногтойд харъяа Эрүүл мэндийн

төв ба аймгийн нэгдсэн эмнэлгийн эмчилгээ хяналтын комисст нас бие гүйцээгүй гэдэг заалтаар жирэмслэлтийг хожуу таслуулахаар илгээж, шийдвэрлүүлнэ.

### **ЗУРГАА: БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРУУД(БЗДХ)**

Өвчний түүх цуглуулж, үзлэгийг оновчтой хийх нь нөхөн үржихүйн замын халдвар/ бэлгийн замаар дамжих халдварыг оношлох, эмчлэх үйлдлийг зөв чиглүүлээд зогсохгүй тухайн үйлчлүүлэгч бэлгийн замаар дамжихалдвар дахин авах, бусдад дамжуулах эрсдэлийг тодорхойлох, хавьтагчдыг илрүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

#### **4.1. Ерөнхий зарчим**

- Бэлгийн замаар дамжих халдвар илрүүлэх үзлэг хийхдээ нууцыг чандлан хадгалах болно гэдгээ урьдчилан хэлнэ,
- Үйлчлүүлэгчээс амьдралын болон өвчний түүх цуглуулах үедээ бэлгийн амьдралын түүхийг авч, бэлгийн харьцаанд орсон эсэх, сүүлийн 3 сард шинээр бэлгийн хавтагчтай байсан эсэх, бэлгийн хавьтагчаа сольдог эсэх, бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн эсэх, бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эсэх зэргийг тодруулна.
- Бэлгийн замаар дамжих халдвар авах бусад эрсдэл, тухайлбал мансууруулах бодис тарилгаар хэрэглэсэн, шинжилгээгүй цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэсэн, шивээс хийлгэсэн эсэхийг нягтлан тодруулна,
- Бэлгийн замаар дамжих халдварын оношлогоо, эмчилгээг хийхдээ "Өсвөр үе залуучуудыг нөхөн үржихүйн замын болон бэлгийн замын халдвараас урьдчилан сэргийлэх тусламж үзүүлэх удирдамж"-ийг мөрдөнө.
- БЗДХ-тай нь тогтоогдвол хавьтагчийг илрүүлэх ба хамт эмчилнэ.
- Дээрх удирдамжинд тусгагдаагүй БЗДХ-ын үед төрөлжсөн мэргэшлийн эмчийн тусламжидшилжүүлнэ.
- Үйлчлүүлэгч бүрт БЗДХ-аас сэргийлэх талаар мэдээлэл өгнө. ТҮБ (Тэвч, Үнэнч бай, Бэлгэвч хэрэглэ) зарчмын талаар тайлбарлана.
- Мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал ба бэлгэвчийг үнэ төлбөргүй хангана.

#### **4.2. Үзлэг хийх**

Хүний биеийн хамгийн нууц хэсэгт үзлэг хийх нь эмчийн зүгээс зохих эв дүй, мэдрэмж, хариуцлагатай байхыг шаарддаг.

##### Үзлэгийн үед эмчийн баримталбал зохих зарчим:

- Эмч мэргэжлийн өндөр түвшинд биеэ авч явах
- Үзлэг хийхдээ ганцаарчилсан байдлыг хангах
- Үзлэг хийхийн ач холбогдлыг тайлбарлан ойлгуулах
- Өөртөө итгэлтэй байж, эргэлзэж тээнэгэлзсэн байдал гаргахгүй байх
- Үзлэг хийхдээ эелдэг харьцах, үйлчлүүлэгч өөрөө хүсээгүй байхад үзлэг хийхгүй байх

#### **Хөвгүүдэд үзлэг хийх**

1. Үзлэгийн өмнө гараа угааж, бээлий өмсөнө.
2. Үзлэгийн үе шат бүрийг үйлчлүүлэгчид тайлбарлан хэлнэ.
3. Үйлчлүүлэгчийг зогсоогоод өмдөө өвдөг хүртлээ шувтлахыг хүснэ.
4. Цавины орчмоор тэмтрэн тунгалгийн булчирхай томорсон эсэхийг үзнэ.
5. Төмсөг, үрийн суваг, төмсөгний дайврыг тэмтэрч үзнэ.

6. Шодойг үзэж яр шархлаа, тууралт байгаа эсэхийг харна.
7. Үйлчлүүлэгчээр тээрхийн арьсыг шамлуулан тээрхий болон шээсний сувгийг үзнэ.
8. Шээсний сувгаас ялгадас гараагүй тохиолдолд үйлчлүүлэгчээр шээсний сувгийгшувтруулан шахуулж, ялгадас байгаа эсэхийг үзнэ.
9. Цааш эргэн бөхийж, өгзөгнөөсөө бага зэрэг татаж үзүүлэхийг хүснэ. Хошного орчимд яр, үү, тууралт, ялгадас байгаа эсэхийг харна.
10. Ялгадас гарч байвал түүний өнгө, хэмжээ, шинж чанарыг үзнэ.
11. Шарх, шалбархай байвал түүний шинж чанар, өнгө, хэлбэр хэмжээг тогтооно.

#### **Охидод үзлэг хийх**

Охидын үзлэг үндсэн 3 хэсгээс бүрдэнэ.

Гадна бэлэг эрхтэний үзлэг

Толины үзлэг(бэлгийн харьцаанд орсон, төрсөн охидуудад)

Хоёр гарын хавсарсан үзлэг(Зөвхөн шаардлагатай тохиолдолд эмэгтэйчүүдийн эмч үзлэг хийнэ).

#### **Гадна бэлэг эрхтэний үзлэг**

Үйлчлүүлэгчийг давсгаа суллахыг хүсч, бэлхүүснээс дооши хувцсаа тайлаад үзлэгийн орон дээр хэвтэхийг хүснэ. Үйлчлүүлэгчийн ичиж зовохыг багасгахын тулд үзлэг хийхгүй биеийн хэсгийг бүтээлгээр хучвал тохиромжтой.

Үйлчлүүлэгчээ эмэгтэйчүүдийн үзлэгийн орон дээр гарган хэвтүүлж өвдгийг хоёр тийш болгон бэлгийн уруул, хязан, хошногоны амсрыг харна.

Цавины орчмоор тэмтрэн тунгалгийн булчирхай томорсон эсэхийг үзнэ

Хэвлийн доод хэсгийг болгоомжтой тэмтэрч үзнэ. Ямар нэгэн өвдөлт илэрч буй эсэхийг шалгана.

Шарх, шалбархай, тууралт байгаа эсэхийг үзэж хэрэв байвал хэлбэр, хэмжээ, өнгө, шинж чанарыг үзнэ.

Үтрээнээс ялгадас гарч буй эсэхийг ажиглана.

#### **Толины үзлэг хийх**

Зөвхөн шаардлагатай үед л толь тавьж үзлэг хийнэ (бэлгийн харьцаанд орсон, төрсөн охидуудад). Үзлэгийн толь нэг удаагийнх юмуу ариутгагдсан байна.

Үтрээний амсраар үзлэгийн толины үзүүрийг оруулж эмэгтэйг биеэ сулласны дараа болгоомжтойгоор түлхэн оруулна.

Үтрээний толины хавхлагыг нээн умайн хүзүүг харна. Умайн хүзүү нь ягаан, гөлгөр, цэвэр салслаг ялгадастай байх нь хэвийн шинж юм.

Умайн хүзүүний гадна хөөмийн байдлыг (нээлттэй эсвэл хаалттай) харна.

Ямар ялгадас гарч байгааг тодруулна.

Үзлэгийн толийг болгоомжтойгоор эргүүлэн үтрээний ханын байдлыг хараад сугалж авна.

#### **4.3. Оношлогоо, эмчилгээ**

Өсвөр үеийн кабинетэд дараах шинжилгээг хийнэ. Үүнд:

- Граммын аргаар будаж шинжлэх
- Нойтон түрхэцийн аргаар шинжлэх
- RPR шинжилгээ
- ХДХВ-ийн халдвар илрүүлэх хурдавчилсан сорил

#### 4.4. Хавьтагчийг илрүүлж эмчлэх

БЗДХ-ын үед хавьтагчийг илрүүлж эмчлэх нь халдвар бусдад тархах, өвчтөн эмчлэгдсэний дараа анх халдвар авсан хүнээсээ дахин халдварлахаас сэргийлэх ач холбогдолтой юм. Гэхдээ хавьтагчийг илрүүлж эмчлэх тухай асуудал бол манай улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжид заасны дагуу сайн дурын үндсэн дээр хэрэгжих ёстойг анхаарах хэрэгтэй.

Халдварын эх үүсвэрийг тогтооно гэдэг нь төвөгтэй төдийгүй заримдаа боломжгүй байдаг. БЗДХ-ын үед үйлчлүүлэгчид эмчлэгдсэнийхээ дараа анх халдвар авсан хүнээсээ дахин халдвар авах эрсдэлтэй тул үйлчлүүлэгчтэй сүүлийн 2 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон бүх хүнийг өвчний шинж тэмдэг илэрсэн эсэхээс хамаарахгүй эмчлэх шаардлагатай. Эмч, эмнэлгийн ажилтан нь үйлчлүүлэгчийн нууцыг баттай хадгалж, хавьтагчийг илрүүлж эмчлэхэд сайн дураараа туслахыг зөвшөөрүүлж чадсанаар гарч болох саад бэрхшээлүүдийг бууруулж чадна.

Хавьтагчийг илрүүлж эмчлэхдээ үйлчлүүлэгчийн бүх бэлгийн хавьтагчийг үйлчлүүлэгчийг эмчилсний адилаар эмчлэх зарчим баримтална. Бэлгийн хавьтагчийн талаар мэдээлэл өгөх эсэх нь ихэнх тохиолдолд үйлчлүүлэгчээс шалтгаалдаг хэдий ч үйлчилгээ үзүүлэгч нь үйлчлүүлэгчдээ тэдний хавьтагч нь БЗДХ-тай байж болох эрсдэлийг ойлгуулж, тэднийг үзлэг, шинжилгээнд хамруулж, эмчлүүлэхийн ач холбогдолыг бүрэн ойлгуулах нь чухал байдаг.

Үйлчлүүлэгчийн хавьтагчтай холбоо тогтоох хоёр арга байна. Үүнд:

- Үйлчлүүлэгчийг явуулах арга
- Эмч эсвэл үйлчилгээ үзүүлэгчийг явуулах арга

Үйлчлүүлэгчийг явуулах арга гэдэг нь үйлчлүүлэгч бэлгийн хавьтагчтайгаа өөрөө холбоо тогтоож, эмчилгээнд ирүүлэхийг хариуцна гэсэн үг. Эмчийг явуулах арга гэдэг нь эмнэлгийн ажилтан үйлчлүүлэгчийн хавьтагчтай уулзаж ярилцахыг хэлнэ. Энэ хоёр арга нь өөр өөрийн давуу талтай боловч үйлчлүүлэгчийг явуулах арга нь илүү ач холбогдолтой.

#### **ДОЛОО: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМЧ НАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ**

**Ерөнхий чиглэл.** Өсвөр үеийнхэн, залуучуудад төрөлжсөн мэргэшлийн тусламжийг хүртээмжтэй, чанартай үзүүлэх, дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэхдээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үндсэн шатлалын дагуу түргэн шуурхай үйлчилнэ.

Өсвөр үеийн кабинетийн эмч нь эмнэлгийн анхан шатны суурь болон яаралтай тусламжийг цаг алдалгүй үзүүлж, шаардлагатай үед төрөлжсөн мэргэшлийн эмчид шилжүүлнэ.

#### 5.1. Үйлчлүүлэгчийг шилжүүлэх зарчим:

- Эрүүл мэндийн дараагийн шатлалын байгууллагад шилжүүлэх, төрөлжсөн мэргэшлийн эмчид үзүүлж, онош тодруулан, эмчлүүлэх шаардлагатай байгааг үйлчлүүлэгч болон түүний асран хамгаалагч/харгалзан дэмжигчид тайлбарлана.
- Үйлчлүүлэгчийн биеийн байдал хүнд, маш хүнд байгаа тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагч/харгалзан дэмжигч эсвэл эмчлэгч эмчөөрийн биеэр дараагийн шатлалын эмнэлэгт хүргэнэ.

- Аймаг, дүүргийн өсвөр үеийн кабинетийн ажилтнууд төрөлжсөн мэргэшлийн эмчид үйлчлүүлэгчийг илгээхдээ үзлэгийн дугаар, цагийг урьдчилан тохирох боломжийг бүрдүүлнэ.

Үйлчлүүлэгчийг шилжүүлэхэд шаардагдах зүйлс:

- Үйлчлүүлэгчийн үзлэгийн карт болон эрүүл мэндийн байгууллагын холбогдох бичиг баримтанд (ЭММ №13 А) үйлчлүүлэгчийн өвчний түүх, урьдчилсан онош, хийгдсэн шинжилгээ, эмчилгээний талаар тодорхой, гаргацтай бичиж тэмдэглэнэ,
- Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн даатгалын дэвтэр, шаардлагатай тохиолдолд иргэний үнэмлэх, эсвэл төрсний гэрчилгээгээ авч явахыг зөвлөнө.

Эргэх холбоо:

- Хэрвээ өсвөр үеийн кабинетийн ажилтан нь үйлчлүүлэгчээ өөрийн биеэр шилжүүлээгүй тохиолдолд үйлчлүүлэгчтэй эргэж харьцах хаяг, утсыг тэмдэглэж авна.
- Өсвөр үеийн кабинетийн эмч нь үйлчлүүлэгч төрөлжсөн мэргэшлийн эмчийн зөвлөгөөг авсны дараа эмнэлгийн холбогдох бичиг баримттай танилцаж, эмчилгээ зөвлөгөөг үргэлжлүүлэн, хяналт тавина.

## 5.2. Төрөлжсөн мэргэшлийн эмч нартай хамтран ажиллах

Тухайн орон нутгийн онцлог байдал, өсвөр үеийнхэн, залуучуудын өөрсдийн хэрэгцээ хүсэлтийг үндэслэн:

- Төрөлжсөн мэргэшлийн зарим эмч (охид, эмэгтэйчүүдийн эмч, сэтгэц мэдрэлийн эмч, арьс гоо заслын эмч, БЗДХ судлалын эмч гэх мэт)-ийг өсвөр үеийн кабинетэд урьж ажиллуулна.
- Үзүүлэх цагийг урьдчилан тохиролцон үйлчлүүлэгчийг тэдэнд илгээнэ. Үйлчлүүлэгч хүсэлт гаргах, эсвэл үйлчлүүлэгчийн биеийн байдал хүнд, маш хүнд байгаа тохиолдолд өсвөр үеийн төвийн ажилтан үйлчлүүлэгчтэй хамт явна,
- Төрөлжсөн мэргэшлийн эмчийн зааврын дагуу үйлчлүүлэгчид зөвлөгөө өгч, эмчилгээ хийж, хянанна.